

БАТЛАВ

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ БОДЛОГО  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА, ТӨСЛИЙН  
ЗАХИРАЛ

Б.БАТ-ӨЛЗИЙ

## БЭЛЧЭЭРИЙН УС ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ГАР ХУДАГ ГАРГАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү удирдамжийн зорилго нь “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” (АДАПТ) төслийн зорилтод аймгуудад гар худаг гаргах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, сонгон шалгаруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, үр дүнг үнэлэх, санхүүжилт олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Удирдамжийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагаа нь малчдын болон малын усан хангамжийг сайжруулах, бэлчээрийн даацын зохистой ашиглалтыг дэмжихэд чиглэнэ.

1.3. Нэр томьёо:

1.3.1. “гар худаг гаргах” гэж энэ удирдамжийн дагуу малчид өөрсдийн хэрэгцээнд зориулан гар аргаар энгийн хийцтэй худаг гаргах үйл ажиллагааг;

1.3.2. “сонгон шалгаруулалт” гэж худаг гаргах хүсэлт ирүүлсэн малчдыг энэхүү удирдамжид заасан шалгуур, онооны аргачлалын үндсэн дээр үнэлж, эрэмбэлэн сонгох үйл явцыг;

1.3.3. “комисс” гэж сонгон шалгаруулалтын үнэлгээний дүнг хэлэлцэж шийдвэр гаргах зорилгоор байгуулагдсан ажлын хэсгийг;

1.3.4. “урамшуулал” гэж ажлын үр дүн, чанар, баталгаажуулалтад үндэслэн олгох санхүүжилтийг;

1.3.5. “баталгаажуулалт” гэж худаг гаргах явцын үе шатны ажлуудын гүйцэтгэлийн фото зураг, GPS координат, газар дээрх хяналтаар нотлох үйл ажиллагааг;

1.3.6. “төсөл хэрэгжүүлэгч” гэж “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” (АДАПТ) төслийг хэрэгжүүлэх нэгжийг;

1.3.7. “Зөвлөх баг” гэж гар аргаар худаг гаргах үйл ажиллагааг зохион байгуулах, техникийн болон мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх Зөвлөх багийг ойлгоно.

### ХОЁР. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

2.1. Зарлан мэдээлэх ажлыг зохион байгуулах

2.1.1. Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь сонгон шалгаруулалтын зарлалыг баталж, албан бичгээр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь сумдын Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлнэ.

2.1.2. Цахим зарыг зөвхөн АДАПТ төслийн цахим хуудаст албан ёсоор нийтлэх ба тэрхүү цахим хуудсаар зарыг түгээх, хуваалцах (share) байдлаар олон нийтэд мэдээллэнэ.

2.1.3. Аймаг, сумын холбогдох мэргэжилтэн, багийн Засаг дарга, АДАПТ төслийн нэгж, орон нутгийн зохицуулагчид зарлалыг малчдад мэдээлэх ажлыг зохион байгуулах ба зарлан мэдээлэх дараах сувгийг ашиглана. Үүнд:

а/ багийн иргэдийн Нийтийн хурал;

б/ сум, багийн зарлалын самбар;

в/ фэйсбүүк, инстаграмм зэрэг олон нийтийн мэдээллийн сүлжээ;

г/ эмэгтэйчүүд болон зорилтот бүлгийн оролцоог хангах, зорилгоор сум, багийн нийгмийн ажилтан, эмэгтэйчүүдийн байгууллагаар дамжуулан мэдээлэх.

2.1.4. Зарлалд дараах мэдээллийг заавал тусгана:

- а/ сонгон шалгаруулалтын зорилго, агуулга;
- б/ бүрдүүлэх материалын жагсаалт;
- в/ хүсэлт хүлээн авах хугацаа;
- г/ хүсэлт хүлээн авах хаяг, холбоо барих утас.

2.1.5. Зарлан мэдээлэх ажлыг 21 хоногийн хугацаанд зохион байгуулах ба энэ хугацаанд малчдын гар худаг гаргах хүсэлтийг хүлээн авах ажлыг зохион байгуулна.

2.2. Хүсэлт хүлээн авах

2.2.1. Малчин нь Хавсралт 1-д заасан материалыг цахимаар Зөвлөх багийн цахим хаягт, хэрэв бичгээр бол АДАПТ төслийн орон нутаг дахь нэгжид тус тус ирүүлнэ.

2.2.2. АДАПТ төслийн орон нутаг дахь нэгж нь малчдаас ирүүлсэн хүсэлтийг нэгтгэж Зөвлөх багт хүргүүлнэ.

2.2.3. Малчдын ирүүлсэн материалыг огноо дарааллын дагуу бүртгэн хүлээж авна.

2.2.4. Зөвлөх баг нь ирүүлсэн материалыг бүрэн эсэхийг хянаж, бүрдэл дутуу материалыг 3 хоногт багтаан бүрдлийг хангуулна.

2.3. Сонгон шалгаруулалт

2.3.1. Ирүүлсэн материалыг үнэлэх комиссыг төсөл хэрэгжүүлэгч байгууллага байгуулна.

2.3.2. Комисс Хавсралт 2-т заасан аргачлалын дагуу материал тус бүрийг үнэлж оноо өгнө.

2.3.3. Онооны үнэлгээгээр 60-аас дээш оноо авсан малчдын хураангуй жагсаалтыг гаргана.

2.3.4. Нэг сумаас 2 ба түүнээс дээш малчин хураангуй жагсаалтад орсон, эдгээр малчдаас сонгох шаардлага үүсвэл тухайн сумын ХАА-н мэргэжилтэнтэй зөвшилцөж болно.

2.3.3. Үнэлгээний онооны дарааллаар Ховд аймагт 10, Завхан аймагт 10, Сүхбаатар аймагт 20 гар худаг гаргах малчныг сонгож, тэмдэглэл хөтөлж баталгаажуулна.

2.4. Үнэлгээний дүнг олон нийтэд мэдээлнэ, үнэлгээний дүнтэй санал нийлэхгүй тохиолдолд 3 хоногт багтаж гомдол гаргаж болно.

2.5. Ирүүлсэн гомдлыг шалгаруулалтын комисс хэлэлцэж 2 хоногт багтаан шийдвэрлэнэ.

## **ГУРАВ. СУРГАЛТ БА ГЭРЭЭНИЙ ҮЕ ШАТ**

3.1. Сургалт зохион байгуулах

3.1.1. Зөвлөх баг сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтыг сонгогдсон малчдад танхимын хэлбэрээр зохион байгуулна.

3.1.2. Сургалтад хамрагдаагүй малчдыг сонгон шалгаруулалтаас хасаж, онооны эрэмбээр дараагийн жагсаалтад орсон малчныг хамруулна.

3.1.3. Сургалтын хөтөлбөрт дараах агуулгыг заавал тусгана:

- а/ бэлчээрийн ус хангамжийг сайжруулах зорилгоор гар худаг гаргах ажлыг зохион байгуулах удирдамж;
- б/ ХХААХҮЯ-ны 2023 оны “Хөдөөгийн усан хангамжийг сайжруулах зарим арга зам” гарын авлага болон энэ удирдамжийн 5 дугаар бүлэгт заасан техникийн шаардлага;
- в/ гар худаг гаргах технологи, ухалт, доторлогоо, амсар хийх заавар;
- г/ хөрсний ус илрүүлэх уламжлалт болон шинжлэх ухааны аргууд;
- д/ аюулгүй ажиллагааны заавар;
- е/ усны менежмент, ундны усны чанарын үндсэн ойлголт;
- ё/ гар худаг гаргах ажлын явц болон үр дүнг баталгаажуулах, баримтжуулах заавар.

3.1.4. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан талаар гарын үсгээр баталгаажуулна.

3.2. Гэрээ байгуулах

3.2.1. Төсөл хэрэгжүүлэгч болон Зөвлөх баг малчинтай гэрээ байгуулна.

3.2.2. Гэрээнд дараах нөхцөлийг заавал тусгана:

- а/ ажлын хамрах цар хүрээ (худгийн хийц, байршил);

- б/ ажлын эхлэх, дуусах хугацаа;
- в/ техникийн чанарын шаардлага (энэхүү удирдамжийн 5 дугаар бүлэгт заасан);
- г/ баримтжуулалтын шаардлага (фото зураг, GPS);
- д/ хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг мөрдөх үүрэг;
- е/ урамшуулал олгох нөхцөл ба санхүүжилтийн зохицуулалт;
- ё/ ус илрээгүй, чанарын шаардлага хангаагүй тохиолдолд авах арга хэмжээ.

3.2.3. Гэрээг 2 хувь үйлдэж талууд гарын үсэг зурна. Шаардлагатай тохиолдолд нотариатаар баталгаажуулна.

### **ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЕ ШАТ**

- 4.1. Малчин худаг гаргах ажлын явцад аюулгүй ажиллагааны дүрмийг баримтална.
- 4.2. Малчин сургалтад хамрагдаж, гэрээ байгуулсны дараа худаг гаргах ажлыг эхлүүлнэ.
- 4.3. Малчин гар худаг гаргах ажлын үе шат бүрийг фото зургаар баримтжуулж, Зөвлөх багт цахимаар илгээнэ.

Үе шат	Авах фото зургийн агуулга	Хугацаа
Эхлэлийн байдал	Газрын гадаргуу, орчны байдал (ухалтаас өмнө), GPS координат	Ухалт эхлэхийн өмнө
Ухалтын явц	Худгийн гүн (хэмжилт), хана бэхэлгээний материал, хана нурахгүй байгаа байдал	Ус гарсны дараа
Доторлогоо	Хашлаганы бүтэц, материал, цемент зуурмагийн хэрэглээ	Доторлогоо хийсний дараа
Амсрын бүтэц	Амсрын өндөр (70 см-ээс дээш), хүзүүвч, таг, хашлага	Амсар дуусгасны дараа
Мал услах онгоц	Онгоцны хийц, үлдэгдэл усыг шавхах ус гаргуур, 2 талын хөвөөг тохижуулсан байдал	Онгоц суурилуулсны дараа
Ус гарсан байдал	Худагт ус байгаа байдал, ус шавхсаны дараах усны гүний хэмжилт	Ус гарсны дараа

Шаардлагатай бол усны чанарын шинжилгээний хийлгэх

### **ТАВ. ХУДАГ ГАРГАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА**

- 5.1. Ерөнхий шаардлага
  - 5.1.1. Гар худаг гаргах ажилд ХХААХҮЯ-ны 2023 оны “Хөдөөгийн усан хангамжийг сайжруулах зарим арга зам” гарын авлагын техникийн шаардлагыг мөрдөж ажиллана.
  - 5.1.2. Худгийн хийц нь усны эх үүсвэрийг хамгаалах, тогтвортой ашиглах боломжийг хангахуйц байна.
- 5.2. Ухалт (худаг малталт)
  - 5.2.1. Худгийн гүн нь усны үе давхаргад хүрэх хүртэл хийгдэнэ.
  - 5.2.2. Нуралтаас сэргийлж ухлагын амсрын диаметрийг 3-4 метрээс багагүй байхаар сонгоно.
  - 5.2.3. Ухалтын явцад дараах аюулгүй ажиллагааны шаардлагыг хатуу мөрдөнө:
    - а/ хамгаалах хэрэгсэл (дуулга, бээлий гэх мэт)-ийг бүрэн ашиглана;
    - б/ ганцаараа ухахыг хориглоно 3 метр ба түүнээс гүнд ажиллах тохиолдолд гадарга дээр 2-оос доошгүй хүн байна;
    - в/ худаг ухах ажлын үед хана нурахаас сэргийлж ханын бэхэлгээг хийнэ;
    - г/ осол гарсан үед шуурхай арга хэмжээ авах, анхны тусламжийн хайрцгийг бэлэн байлгах.

### 5.3. Доторлогоо (хана бэхэлгээ)

5.3.1. Ханын нуралтаас хамгаалах зорилгоор доторлогоо заавал хийнэ.

5.3.2. Худгийн доторлогооны материал нь усны чанарт сөрөг нөлөө үзүүлэхээргүй материалаар хийгдсэн байна.

5.3.3. Доторлогоо нь бат бөх, ус нэвтрүүлэх чадварыг алдагдуулахааргүй байна.

5.3.4. Уст үеийн хэсэгт шүүрүүлэх боломжтой хийц (хайрга 2-5 см ширхэгтэй) байхаар төлөвлөнө.

### 5.4. Амсар

5.4.1. Худгийн амсрыг газрын гадаргуугаас дор хаяж 70 см өндөрт хийж, бохирдлоос хамгаална.

5.4.2. Амсар нь хүзүүвчтэй, нээгдэж хаагддаг тагтай байна.

5.4.3. Амсрын орчмыг ус үл нэвтрүүлэх шавраар манаж, гадаргын буюу үерийн ус нэвчихээс хамгаална.

5.4.4. Мал, хүн унах эрсдэлээс хамгаалах хамгаалалт хийнэ.

## **ЗУРГАА. ҮНЭЛГЭЭ БА УРАМШУУЛАЛ**

### 6.1. Үр дүнг үнэлэх

6.1.1. Малчдын гаргасан гар худгийг Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөл, аймгийн/сумын хөдөө ахуйн мэргэжилтэн, сумын байгаль хамгаалагч, багийн Засаг дарга хүлээж авна.

6.1.2. Усны мэдээллийн санд бүртгэхэд шаардлагатай гар худгийн мэдээллийг худгийн паспортод бичиж Сав газрын захиргаанд мэдээлэх ажлыг сумын байгаль хамгаалагч хариуцан гүйцэтгэнэ.

### 6.2. Урамшуулал

6.2.1. Гар худаг гаргах ажлын зардлыг малчин өөрийн хөрөнгөөр урьдчилан санхүүжүүлнэ.

6.2.2. Гүйцэтгэл нь гэрээ болон удирдамжийн шаардлагыг хангаж, хяналтаар баталгаажсан тохиолдолд урамшууллыг төсөл хэрэгжүүлэгч байгууллага олгоно.

6.2.3. Гар худаг гаргасан зардлын хэмжээг Хавсралт 3-д заасан аргачлалын дагуу тооцож нийт өртөг 8.3 сая төгрөгт багтаж байвал гаргасан зардлыг урамшуулал хэлбэрээр шууд олгох бөгөөд 8.3 сая төгрөгөөс давсан зардлыг олгох асуудлыг төсөл хэрэгжүүлэгч байгууллага шийднэ.

6.2.4. Урамшуулал олгох зардлыг зөвхөн удирдамжийн 5 дугаар бүлэгт заасан техникийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн энгийн хийцтэй гар худаг дээр тооцно. Малчин өөрийн санаачилгаар инженерийн хийтэй тоноглол болон нэмэлт ажил хийсэн бол тэрхүү зардлыг малчин өөрөө бүрэн хариуцах бөгөөд урамшуулалд тооцохгүй.

6.2.5. Зөвлөх баг гэрээний үүргийг хангалттай биелүүлсэн, урамшуулал олгох малчдын нэрсийг тайлан, нотлох баримтын хамт төсөл хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлэх бөгөөд тус байгууллага урамшууллыг малчны хувийн дансанд шилжүүлнэ.

6.2.6. Төсөл хэрэгжүүлэгч дараах тохиолдолд урамшуулал олгохоос татгалзана.

а/ ажил хийгдээгүй;

б/ ус гараагүй буюу техникийн чанарын шаардлага хангаагүй;

в/ баримтжуулалт хийгдээгүй буюу хуурамч мэдээлэл илэрсэн.

## **ДОЛОО. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

### 7.1. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага

#### 7.1.1. Эрх:

а/ Удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих;

б/ гүйцэтгэлийг баталгаажуулах, шаардлага хангаагүй тохиолдолд санхүүжилт олгохоос татгалзах;

в/ гэрээний хэрэгжилтийг дүгнэх, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах.

#### 7.1.2. Үүрэг:

а/ нутгийн захиргааны байгууллагатай харилцах албан харилцааг дэмжих;

б/ сургалт зохион байгуулахад танхимаар хангах;

в/ малчдад олгох урамшууллын санхүүгийн гүйлгээг зохион байгуулах;

г/ удирдамжийн хэрэгжилтийг зохион байгуулж, нийт үйл ажиллагаанд хяналт тавих.

#### 7.2. Зөвлөх баг

##### 7.2.1. Эрх:

а/ материалд үнэлгээ хийх, дүгнэлт гаргах;

б/ гүйцэтгэлд техникийн хяналт тавих;

в/ шаардлага хангаагүй ажлыг сайжруулах зөвлөмж өгөх.

##### 7.2.2. Үүрэг:

а/ сонгон шалгаруулалтын зарлалыг боловсруулах, зохион байгуулах;

б/ малчинтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах;

в/ сургалт зохион байгуулах;

г/ ажлын гүйцэтгэлийн явцад мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

д/ явцын хяналт болон эцсийн үр дүнгийн үнэлгээг зохион байгуулах.

#### 7.3. Малчны эрх, үүрэг

##### 7.3.1. Эрх:

а/ сонгон шалгаруулалтад тэгш оролцох;

б/ сургалт, зөвлөгөөнд хамрагдах;

в/ гүйцэтгэл шаардлага хангасан тохиолдолд урамшуулал авах;

г/ гомдлоо холбогдох байгууллагад гаргах.

##### 7.3.2. Үүрэг:

а/ гар аргаар худаг гаргах ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх;

б/ сургалтад оролцох зардлаа өөрсдөө хариуцах;

в/ удирдамж болон гэрээний шаардлагыг мөрдөх;

г/ ажлын явцыг фото зураг болон шаардлагатай мэдээллээр баримтжуулах;

д/ хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, үүсэх эрсдэлийг өөрөө хариуцах;

е/ худаг гаргах ажил амжилтгүй болсон (ус илрээгүй, техникийн шаардлага хангаагүй) тохиолдолд үүсэх үр дагаврыг өөрөө бүрэн хариуцах.

~~~~~ 000 ~~~~~

## ГАР ХУДАГ ГАРГАХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

## ОРОЛЦОГЧИЙН БҮРТГЭЛ

Тайлбар:

\* нь заавал бөглөх асуулт;

○ ○ ○ \_ аль нэгийг тэмдэглэнэ;

□ □ □ \_ олон сонголт байж болно.

1. Аймгийн нэр\*: \_\_\_\_\_
2. Сумын нэр\*: \_\_\_\_\_
3. Багийн нэр\*: \_\_\_\_\_
4. Овог нэр\*: \_\_\_\_\_
5. Регистрийн дугаар\*: \_\_\_\_\_
6. Утасны дугаар\* /2-оос доошгүй дугаар бичих/:  
\_\_\_\_\_

7. Өмнө нь АДАПТ төслөөс дэмжлэг авч байсан эсэх\*:

*/Тийм бол бусад гэсэн хэсэгт хамрагдсан төсөл, үйл ажиллагааны талаар бичих/.*
 Тийм       Үгүй       Бусад: \_\_\_\_\_

8. Оршин суугаа багийн Засаг даргын тодорхойлолт\*:

*/Тодорхойлолтыг хүсэлтэд хавсаргана/.*

## ӨРХИЙН МЭДЭЭЛЭЛ

9. Ам бүлийн тоо\*: \_\_\_\_\_
10. Ам бүлд хөгжлийн бэрхшээлтэй гишүүн байдаг эсэх\*:  
 Тийм                                       Үгүй
11. Өрхийн тэргүүний мэдээлэл\*:  
 Эрэгтэй                                       Эмэгтэй
12. Өрх толгойлсон эцэг, эх эсэх\*:  
 Тийм                                       Үгүй
13. Насны ангилал\*:  
 18 – 30 нас                               31 – 59 нас                               60 түүнээс дээш

## МАЛЫН ТОО ТОЛГОЙ

Малын тоо\* /5 төрлөөр/:

14. Адуу\*: \_\_\_\_\_

15. Үхэр\*: \_\_\_\_\_

16. Тэмээ\*: \_\_\_\_\_

17. Хонь\*: \_\_\_\_\_

18. Ямаа\*: \_\_\_\_\_

## ГАР ХУДАГ ГАРГАХ СОНИРХЛОО ИЛЭРХИЙЛСЭН ХҮСЭЛТ

*/Гар худаг гаргах хэрэгцээ шаардлага, ач холбогдлын талаар 2–5 өгүүлбэрээр товч, тодорхойлж бичнэ/.*

19. Хэрэгцээ шаардлага\*:

---

---

---

---

---

---

---

---

---

---

20. Ач холбогдол\*:

---

---

---

---

---

---

---

---

---

---

21. Бэлчээр ашиглалт\*:

- Одоогоор ашиглагдаагүй бэлчээрийг ашиглах боломж бүрдэнэ.
- Бэлчээрийн сэлгэлт хийх боломж бүрдэнэ.
- Бэлчээрийн сэлгэлтэд нөлөө үзүүлэхгүй.

22. Бэлчээр ашиглалтын гэрээтэй бол хуулбарыг, гэрээгүй бол сэлгэлт хийх төлөвлөлтийн тойм зураг/схем хавсаргах:

*/Хүсэлтэд хавсаргаж ирүүлэх/.*

## ХУДАГ ГАРГАХ БАЙРШИЛ

### 23. Газрын нэр\*:

*/Худаг гаргах газрын нэрийг тодорхой, зөв оруулах. Жишээ нь: 5-р багийн нутаг, Ширээт хайрхан, Богинын ам гэх мэт/.*

### 24. Худаг гаргах байршлын солбицол:

*/Гар утас, GPS-ээр солбицлыг тодорхойлох, эсвэл гар утасны Google тар ашиглан байршлыг олж координатыг оруулах/*

### 25. Гар худаг гаргах газрын онцлог, газрын гадаргуун ерөнхий байдлыг товч тодорхойлж бичих\*:

### 26. Газрын ерөнхий тогтцыг харуулсан фото зураг хавсаргах\*:

*/Хүсэлтэд хавсаргаж ирүүлнэ/.*

### 27. Хамгийн ойрын уст цэгээс алслагдсан зай, км\*:

- 7 км дотор ямар ч уст цэг байхгүй  3 км зайд уст цэг байхгүй  
 5 км зайд уст цэг байхгүй  2 км дотор уст цэг байгаа

### 28. Ашиглах хугацаа\*:

- Өвөл  Хавар  Зун  Намар

### 29. Шинээр гаргах худгаас усаар хангагдах өрхийн тоо\*:

### 30. Шинээр гаргах худгаас услах малын тоо\*:

## ХУДГИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ /Урьдчилсан төсөөлөл/

### 31. Ус гарах боломж\*:

*"Бусад" хэсгийг сонговол ус гарах боломжтой гэж байгаа үндэслэлийг тодорхойлж бичнэ/.*

- Өмнө худаг байсан  
 Булаг байсан  
 Бусад: \_\_\_\_\_

### 32. Худгийн гүн\*:

- 3 метр хүртэл  3 – 5 метр  
 5 – 10 метр  10 метрээс гүн

33. Доторлогооны материал\*:

Чулуу       Мод       Бусад: \_\_\_\_\_

34. Худгийн амсар\*:

Мод       Төмөр       Бусад: \_\_\_\_\_

35. Мал услах онгоцны хийц\*: \_\_\_\_\_

36. Мал услах онгоцны урт, метрээр\*: \_\_\_\_\_

37. Ус татах арга\*:

Ховоо       Гар насос       Бусад: \_\_\_\_\_

38. Баримжаалсан төсөвт өртөг\*:

*/Гар худаг гаргах зардлын тойм тооцоог хийж, мөнгөн дүнг оруулах/.*  
тоогоор,

\_\_\_\_\_ үсгээр

Гар худаг гаргах  
хүсэлт гаргасан:  
Малчны овог нэр

\_\_\_\_\_

Гарын үсэг:

\_\_\_\_\_

Огноо:

\_\_\_\_\_

Хүсэлтийг хүлээн авсан:

Овог нэр/албан тушаал

\_\_\_\_\_

Гарын үсэг:

\_\_\_\_\_

Огноо:

\_\_\_\_\_

~~~~~ 000 ~~~~~

## ОНООНЫ ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Бэлчээрийн ус хангамжийг сайжруулах зорилгоор гар худаг гаргах малчдыг сонгон шалгаруулах

Нийт оноо тооцоолох томьёо

Нийт оноо =  $\Sigma$  (Усны хэрэгцээ + Ус гарах боломж + Бэлчээрийн ашиглалт + Малын бүтэц + Нийгмийн хүчин зүйл)

Нийт дээд оноо: 100 | Сонгох босго: 60 оноо

| Шалгуур үзүүлэлт                       | Дэд шалгуур / Нөхцөл                                       | Оноо |
|--|--|------|
| 1. Усны хэрэгцээ<br>(25 оноо)          | 7 км дотор ямар ч уст цэг байхгүй                          | 25   |
|  | 5 км зайд уст цэг байхгүй                                  | 15   |
|  | 3 км зайд уст цэг байхгүй                                  | 10   |
|  | 2 км дотор уст цэг байгаа                                  | 0    |
| 2. Ус гарах боломж<br>(20 оноо)        | Өмнө нь худаг байсан / булаг байсан нотлох баримт бий      | 20   |
|  | Геологийн боломж дунд зэрэг (нотлох баримт хязгаарлагдмал) | 10   |
|  | Ус гарах боломж тодорхойгүй / эрсдэлтэй                    | 0    |
| 3. Бэлчээр ашиглалт<br>(25 оноо)       | Одоогоор ашиглагдаагүй бэлчээрийг ашиглах боломжтой болно  | 25   |
|  | Бэлчээрийн сэлгээ хийдэг байх                              | 15   |
|  | Бэлчээрт нөлөө бага / тодорхойгүй                          | 0    |
| 4. Сүргийн зохистой бүтэц<br>(15 оноо) | Зохистой бүтцийн хазайлт 0-10%                             | 15   |
|  | Зохистой бүтцийн хазайлт 11-30%                            | 10   |
|  | Зохистой бүтцийн хазайлт 31-50%                            | 5    |
|  | Зохистой бүтцийн хазайлт > 51%                             | 0    |
| 5. Нийгмийн хүчин зүйл<br>(15 оноо)    | Өрх толгойлсон эмэгтэй / эмзэг бүлгийн малчин              | 15   |
|  | Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх / ахмад малчин          | 10   |
|  | Энгийн өрх (онцгой нөхцөл байдалгүй)                       | 0    |

Тайлбар: Сүргийн бүтэц \* ХХААХУ-ийн сайдын 2020.01.15-ны А-15 дугаар тушаалаар батлагдсан "Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги: 2020-2030 он" бодлогын баримт бичиг., 2030 оны түвшинд хонь 40%, ямаа 30%, бод мал 30% болгож, сүргийн бүтцийн зохистой харьцааг хангах.

## ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН БА ШИЙДВЭР

| Оноо   | Шийдвэр       | Тайлбар  |
|--------|---------------|--|
| 80–100 | Шууд сонгох   | Шаардлага бүрэн хангасан. Гэрээ байгуулах шатанд шилжинэ.                |
| 60–79  | Нөөц жагсаалт | Нөөц жагсаалтад бүртгэгдэнэ. Эхний жагсаалтаас гарвал орлуулна.          |
| <60    | Хасах         | Шаардлага хангаагүй. Дараагийн цикл дэх зарлалд дахин оролцох боломжтой. |

### ◆ Тэмдэглэл

- Үнэлгээг зөвхөн баримт бичигт тулгуурлан гүйцэтгэнэ. Нотлогдоогүй мэдэгдэл оноонд тооцогдохгүй.
- Ижил оноотой өргөдлийн хувьд «Нийгмийн хүчин зүйл» (5-р шалгуур) давуу тал болно.

~~~~~ 000 ~~~~~

**ГАР ХУДАГ ГАРГАХ АЖЛЫН ЖИШИГ ҮНЭЛГЭЭ**

Бэлчээрийн ус хангамжийг сайжруулах зорилгоор гар худаг гаргах малчдад урамшуулал олгох

Гар худаг гаргасан малчдад олгох урамшууллын хэмжээг 3 метр хүртэлх гүнтэй худагт хүснэгтэд оруулсан жишиг үнэлгээгээр тооцох ба, 3 метрээс дээш гүнтэй худагт ухалт, доторлогоо хийх ажлын хөлс болон доторлогооны материалын зардал метр бүрд 500'000 төгрөг нэмэгдэхээр тооцно.

**3 метр хүртэлх гүнтэй гар худаг гаргах зардлын жишиг үнэлгээ**

| д.д.                        | Худгийн хийц болон материал         | Нэгж           | Тоо хэмжээ | Нэгж үнэ (₮) | Нийт үнэ (₮)     |
|-----------------------------|-------------------------------------|----------------|------------|--------------|------------------|
| 1                           | Ухалт (гар ажиллагаа)               | м              | 3          | 350'000      | 1'050'000        |
| 2                           | Доторлогоо (чулуу/мод/бетон)        | м              | 3          | 300'000      | 900'000          |
| 3                           | Ёроолын хийц, ус шүүрүүлэх материал | ш              | 1          | 250'000      | 250'000          |
| 4                           | Амсар                               | ш              | 1          | 500'000      | 500'000          |
| 5                           | Таг, хамгаалалт                     | ш              | 1          | 300'000      | 300'000          |
| 6                           | Онгоц                               | м              | 10         | 80'000       | 800'000          |
| 7                           | Онгоцны суурь                       | ш              | 4          | 200'000      | 200'000          |
| 8                           | Хөвөө                               | м <sup>2</sup> | 50         | 12'000       | 600'000          |
| 9                           | Хашаа                               | ш              | 1          | 700'000      | 700'000          |
| 10                          | Хаалга, тулгуур                     | ш              | 1          | 300'000      | 300'000          |
| 11                          | Тээвэр                              | ш              | 1          | 200'000      | 200'000          |
| 12                          | Багаж                               | ш              | 1          | 100'000      | 100'000          |
| 13                          | Нөөц                                | ш              | 1          | 100'000      | 100'000          |
| <b>Жишиг үнэлгээний дүн</b> |                                     |                |            |              | <b>6'000'000</b> |


**Уралдаанд шалгарсан малчинд олгох урамшууллын хэмжээ**

| Худгийн гүн   | Урамшууллын хэмжээ |
|---------------|--------------------|
| 3 метр хүртэл | 6'000'000.0        |
| 4 метр        | 6'500'000.0        |
| 5 метр        | 7'000'000.0        |
| 6 метр        | 7'500'000.0        |
| 7 метр        | 8'000'000.0        |
| 8 метр        | 8'500'000.0        |
| 9 метр        | 9'000'000.0        |
| 10 метр       | 9'500'000.0        |

Хянасан:

АДАПТ төслийн үндэсний зохицуулагч

УАӨ-д зохицсон төлөвлөлтийн техникийн мэргэжилтэн



Б.Эрдэнэбилэг

Б.Саранцэцэг

Боловсруулсан:

Зөвлөх баг - "Ус хөгжил, ирээдүй төв" НҮТББ

Г.Долгорсүрэн

П.Магсаржав

Б.Оюунболд

